



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэрлэг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2023/22-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: <a href="mailto:Baigalmaat@audit.gov.mn">Baigalmaat@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: <a href="mailto:Nerguibaatard@audit.gov.mn">Nerguibaatard@audit.gov.mn</a> Ахлах аудитор П.Цэцэгдулам Цахим хаяг: <a href="mailto:Tsetsegdulamp@audit.gov.mn">Tsetsegdulamp@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Ус, цаг уур орчны шинжилгээний төв нь Улсын төсвийн харьяа төсвийн байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд явуулж байна.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.5.3 Нэмэлт төсөв .....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс:976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.02.13 № 43

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ЭРДЭНЭБАТ  
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

Засаг даргын нөөц хөрөнгөөс Сумын засаг даргын нэрэмжит олон төрөлтийн тэмцээн, "Цэцэрлэгт үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааны шагналд нийт 5885.0 мянган төгрөг олгосон нь бидний тооцсон материаллаг хэмжээнээс хэтэрсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллага Засаг даргын Тамгын газрын дарга нь үүрэгт ажлаас чөлөөлөгдөж түр орлон гүйцэтгэгч томилогдон ажиллаж байна.

### Аудитын гол асуудал

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 33.4, 33.5 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор ЗДТГазрын орон тооны дээд хязгаарыг 16 орон тоотой байхаар баталсан байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 135 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 98.5 хувьтай үнэлсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>58,968,088.00</b>	<b>62,277,788.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>58,968,088.00</b>	<b>62,277,788.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>58,968,088.00</b>	<b>62,277,788.00</b>
35410	Бичиг хэргийн материал	81,500.00	81,500.00
35420	Аж ахуйн материал	56,636,588.00	60,406,288.00
35440	Түлш, шатах тослох материал	2,250,000.00	1,790,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,979,102,584.14</b>	<b>1,992,097,905.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,979,102,584.14</b>	<b>1,992,097,905.89</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,928,671,250.66</b>	<b>1,942,445,322.34</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	971,085,080.00	991,085,080.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-73,397,226.64	-90,316,244.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	150,652,875.00	150,652,875.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-96,869,472.34	-109,026,482.97
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	84,831,884.00	185,889,834.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,575,320.63	-62,319,032.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	189,088,953.02	141,471,857.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	-58,971,748.61	-67,327,230.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,145,151,380.00	1,213,185,680.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-347,354,503.14	-412,318,363.03
39217	Ном	1,029,350.00	1,467,350.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>50,431,333.48</b>	<b>49,652,583.55</b>
39301	Програм хангамж	4,935,000.00	4,935,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,167,666.52	-3,946,416.45
39303	Бусад биет бус хөрөнгө	48,664,000.00	48,664,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,038,070,672.14</b>	<b>2,054,375,693.89</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>349,570.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>349,570.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>349,570.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0.00</b>	<b>349,570.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	349,570.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,038,070,672.14</b>	<b>2,054,026,123.89</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,038,070,672.14</b>	<b>2,054,026,123.89</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	520,124,120.00	520,124,120.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	520,124,120.00	520,124,120.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,017,441,901.14</b>	<b>1,033,397,352.89</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	989,952,367.80	1,017,441,901.14
51220	Тайлант үеийн үр дүн	27,489,533.34	15,955,451.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	500,504,651.00	500,504,651.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,038,070,672.14</b>	<b>2,054,375,693.89</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>638,249,908.02</b>	<b>618,212,563.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>157,407,619.02</b>	<b>104,508,918.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>157,407,619.02</b>	<b>104,508,918.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,600,000.00</b>	<b>6,104,800.00</b>

**Цэцэрлэг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,600,000.00	827,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	5,277,000.00
120009	Бусад орлого	0.00	12,657,818.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	153,452,619.02	76,086,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,355,000.00	9,660,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>480,842,289.00</b>	<b>513,703,645.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>28,957,089.00</b>	<b>2,392,645.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,957,089.00	2,200,645.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	192,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>451,885,200.00</b>	<b>511,311,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	451,885,200.00	511,311,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>609,880,374.68</b>	<b>596,367,111.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>609,880,374.68</b>	<b>596,367,111.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>504,166,075.68</b>	<b>506,013,905.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>222,087,114.00</b>	<b>225,381,647.20</b>
210101	Үндсэн цалин	222,087,114.00	203,730,517.90
210102	Нэмэгдэл	0.00	21,651,129.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,071,903.00</b>	<b>28,154,832.15</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,366,886.60	19,157,634.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,263,517.24	2,325,216.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,800,735.25	1,850,093.29
210204	Ажилгүйдлийн даатгал	759,239.93	438,353.36
210205	Эрүүл мэндийн даатгал	3,881,523.98	4,383,534.37
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,842,970.00</b>	<b>15,724,504.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,203,810.00	2,986,504.00
210302	Түлш, халаалт	9,389,160.00	12,588,000.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	150,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,646,583.00</b>	<b>18,276,720.00</b>
210401	Бичиг хэрэг	3,927,800.00	1,954,800.00
210402	Тээвэр, шатахуун	22,332,783.00	12,344,770.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,835,000.00	2,005,000.00
210404	Ном, хэвлэл	167,800.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	995,100.00	766,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,388,100.00	1,206,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,675,000.00</b>	<b>0.00</b>
210502	Хоол, хүнс	2,875,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,329,000.00</b>	<b>500,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,855,500.00	0.00
210604	Урсгал засвар	6,473,500.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,946,000.00</b>	<b>4,901,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,946,000.00	4,901,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,430,501.00</b>	<b>21,699,324.00</b>

**Цэцэрлэг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,394,287.00	21,567,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	879,500.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,574.00	77,574.00
210807	Газрын төлбөр	24,690.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>184,137,004.68</b>	<b>191,375,878.25</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,629,519.00	46,758,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	145,507,485.68	144,616,978.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>105,714,299.00</b>	<b>90,353,205.65</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>601,600.00</b>	<b>19,740,140.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	18,940,140.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	601,600.00	800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>105,112,699.00</b>	<b>70,613,065.65</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,112,699.00	70,420,920.65
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	192,145.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>28,369,533.34</b>	<b>21,845,451.75</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>880,000.00</b>	<b>5,890,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	880,000.00	5,890,000.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>27,489,533.34</b>	<b>15,955,451.75</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>482,442,289.00</b>	<b>527,189,263.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,600,000.00</b>	<b>13,485,618.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,600,000.00</b>	<b>13,485,618.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,600,000.00</b>	<b>827,800.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,600,000.00	827,800.00
120009	Бусад орлого	0.00	12,657,818.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>480,842,289.00</b>	<b>513,703,645.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>28,957,089.00</b>	<b>2,392,645.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	464,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,957,089.00	1,736,445.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	192,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>451,885,200.00</b>	<b>511,311,000.00</b>

Цэцэрлэг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	451,885,200.00	511,311,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>469,512,289.00</b>	<b>439,773,263.00</b>
299990	Устгал	0.00	0.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>469,512,289.00</b>	<b>439,773,263.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>363,711,590.00</b>	<b>349,420,057.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>222,087,114.00</b>	<b>225,381,647.20</b>
210101	Үндсэн цалин	222,087,114.00	203,730,517.90
210102	Нэмэгдэл	0.00	21,651,129.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,071,903.00</b>	<b>28,154,832.15</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,366,884.60	19,088,832.15
210202	Тэтгэмжийн даатгал	2,263,519.24	2,266,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,800,735.25	1,813,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	418,574.49	453,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,222,189.42	4,533,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,242,970.00</b>	<b>14,434,504.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,203,810.00	2,986,504.00
210302	Түлш, халаалт	9,789,160.00	11,298,000.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	150,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,749,850.00</b>	<b>17,927,150.00</b>
210401	Бичиг хэрэг	3,687,100.00	1,954,800.00
210402	Тээвэр, шатахуун	15,001,450.00	11,995,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,835,000.00	2,005,000.00
210404	Ном, хэвлэл	376,300.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	766,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,850,000.00	1,206,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,675,000.00</b>	<b>0.00</b>
210502	Хоол, хүнс	2,875,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,329,000.00</b>	<b>500,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,855,500.00	0.00
210604	Урсгал засвар	6,473,500.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,946,000.00</b>	<b>4,901,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,946,000.00	4,901,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,928,254.00</b>	<b>21,699,324.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,892,040.00	21,567,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	879,500.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,574.00	77,574.00
210807	Газрын төлбөр	24,690.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>50,681,499.00</b>	<b>36,421,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,681,499.00	36,421,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>105,800,699.00</b>	<b>90,353,205.65</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>688,000.00</b>	<b>19,740,140.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	18,940,140.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	688,000.00	800,000.00

Цэцэрлэг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>105,112,699.00</b>	<b>70,613,065.65</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	105,112,699.00	70,420,920.65
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	192,145.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>12,930,000.00</b>	<b>87,416,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>12,930,000.00</b>	<b>87,416,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>12,930,000.00</b>	<b>87,416,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>12,930,000.00</b>	<b>87,416,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,930,000.00	87,416,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-12,930,000.00</b>	<b>-87,416,000.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,124,120.00	511,058,339.04	979,398,679.76	2,010,581,138.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	10,553,688.04	10,553,688.04
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	520,124,120.00	511,058,339.04	989,952,367.80	2,021,134,826.84
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	-10,553,688.04	0.00	-10,553,688.04
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	27,489,533.34	27,489,533.34
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,124,120.00	500,504,651.00	1,017,441,901.14	2,038,070,672.14
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	520,124,120.00	500,504,651.00	1,017,441,901.14	2,038,070,672.14
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	520,124,120.00	500,504,651.00	1,017,441,901.14	2,038,070,672.14
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	15,955,451.75	15,955,451.75
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	520,124,120.00	500,504,651.00	1,033,397,352.89	2,054,026,123.89

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>512,899,000.00</b>	<b>454,375,697.35</b>	<b>454,375,697.35</b>	<b>0.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,799,000.00	367,397,697.35	367,397,697.35	0.00

Цэцэрлэг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>392,863,000.00</b>	<b>347,657,557.35</b>	<b>347,657,557.35</b>	<b>0.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>227,885,300.00</b>	<b>225,381,647.20</b>	<b>225,381,647.20</b>	<b>0.00</b>
210101	Үндсэн цалин	227,885,300.00	203,730,517.90	203,730,517.90	0.00
210102	Нэмэгдэл	0.00	21,651,129.30	21,651,129.30	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,485,600.00</b>	<b>28,154,832.15</b>	<b>28,154,832.15</b>	<b>0.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,370,200.00	19,088,832.15	19,088,832.15	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,278,800.00	2,266,500.00	2,266,500.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,823,100.00	1,813,100.00	1,813,100.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	455,800.00	453,400.00	453,400.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,557,700.00	4,533,000.00	4,533,000.00	0.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,000,000.00</b>	<b>14,434,504.00</b>	<b>14,434,504.00</b>	<b>0.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,700,000.00	2,986,504.00	2,986,504.00	0.00
210302	Түлш, халаалт	13,000,000.00	11,298,000.00	11,298,000.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	150,000.00	150,000.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,407,200.00</b>	<b>17,331,950.00</b>	<b>17,331,950.00</b>	<b>0.00</b>
210401	Бичиг хэрэг	2,239,200.00	1,954,800.00	1,954,800.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	11,400,000.00	11,400,000.00	11,400,000.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,140,000.00	2,005,000.00	2,005,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,288,000.00	766,150.00	766,150.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,340,000.00	1,206,000.00	1,206,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,080,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	1,080,000.00	500,000.00	500,000.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,500,000.00</b>	<b>4,901,000.00</b>	<b>4,901,000.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,500,000.00	4,901,000.00	4,901,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>39,457,100.00</b>	<b>20,532,024.00</b>	<b>20,532,024.00</b>	<b>0.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,923,300.00	20,400,000.00	20,400,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,188,800.00	0.00	0.00	0.00

**Цэцэрлэг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210803	Даатгалын үйлчилгээ	60,000.00	54,450.00	54,450.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	77,574.00	77,574.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	205,000.00	0.00	0.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>55,047,800.00</b>	<b>36,421,600.00</b>	<b>36,421,600.00</b>	<b>0.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,047,800.00	36,421,600.00	36,421,600.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,936,000.00</b>	<b>19,740,140.00</b>	<b>19,740,140.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,936,000.00</b>	<b>19,740,140.00</b>	<b>19,740,140.00</b>	<b>0.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,736,000.00	18,940,140.00	18,940,140.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	800,000.00	800,000.00	0.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>95,100,000.00</b>	<b>86,978,000.00</b>	<b>86,978,000.00</b>	<b>0.00</b>
220001	Барилга байгууламж	20,000,000.00	20,000,000.00	20,000,000.00	0.00
221001	Их засвар	3,500,000.00	0.00	0.00	0.00
222001	Тоног төхөөрөмж	67,100,000.00	66,978,000.00	66,978,000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	4,500,000.00	0.00	0.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>512,899,000.00</b>	<b>454,375,697.35</b>	<b>454,375,697.35</b>	<b>0.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>453,547,897.35</b>	<b>453,547,897.35</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00	453,547,897.35	453,547,897.35
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>383,396,400.00</b>	<b>453,547,897.35</b>	<b>0.00</b>	<b>453,547,897.35</b>
320001	Орон нутгийн төсвөөс	383,396,400.00	453,547,897.35	0.00	453,547,897.35
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>129,502,600.00</b>	<b>827,800.00</b>	<b>827,800.00</b>	<b>0.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,588,000.00	827,800.00	827,800.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	127,914,600.00	0.00	0.00	0.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>51.00</b>	<b>51.00</b>	<b>0.00</b>	<b>51.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>25.00</b>	<b>25.00</b>	<b>0.00</b>	<b>25.00</b>

**Цэцэрлэг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

620001	Удирдах ажилтан	7.00	7.00	0.00	7.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	0.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	5.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25.00</b>	<b>25.00</b>	<b>0.00</b>	<b>25.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00	0.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	13.00	0.00	13.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3.00	3.00	0.00	3.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2392645
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2392645
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2392645
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	595200
210402	Тээвэр, шатахуун	595200
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1605300
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1605300
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	192145
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	192145
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	192145
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2392645
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2392645
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	464200
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1736445
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	192000

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Тайлант онд Цэцэрлэг сумын ЗДТГ нь “Аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, мэдлэг чадварт суурилсан, идэвх санаачилгатай чадварлаг албан хаагч бүхий төрийн албыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэнэ” гэсэн зорилт тавин ажиллажээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Цэцэрлэг сумын ЗДТГ нь аймгийн ТЕЗ-ийн харьяа төсвийн байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа монгол улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд явуулж байна.**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022.04.29
- “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2022.05.25-ны 203 дугаар тогтоол
- “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” ЗГ-ын 2022.03.09-ны 107 дугаар тогтоол
- “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2022.05.11-ны 192 дугаар тогтоол
- “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2022.05.11-ны 194 дүгээр тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/841 дугаар захирамжаар баталсан “Аймгийн ТЕЗ-ийн багцын харьяа төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байна. Энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,989.1 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	58968.0	62277.7	3309.7
Үндсэн хөрөнгө	2595438.5	1992097.9	(603340.6)
<b>Нийт хөрөнгө</b>	2654406.5	2054375.6	(600030.8)
Өр төлбөр	-	-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2038070.6	2054026.1	15955.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2038070.6	2054026.1	15955.5

Хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 5.6 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 58968.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 52997.3 мянган төгрөг, Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал 9187.0 мянган төгрөг нийт 62184.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 58874.6 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 62277.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 23.2 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 2595438.5 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 76086.3 мянган төгрөг, шилжүүлэн авсан 42890.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 87416.0 мянган төгрөг, нийт 206392.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан элэгдэл 745253.7 мянган төгрөг, орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлөөр 15699.1 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан, ЕБС-д 3600.0 мянган төгрөгийн хөрөнгө, Хүүхдийн цэцэрлэгт 2290.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлж нийт 603340.6 мянган төгрөгөөр буурч 1992097.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнг 15955.4 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 382813.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 8453.8 мянган төгрөгийг бууруулан зардлыг 374359.5 мянган төгрөгөөр хянаж баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд онд батлагдсан төсвийг сумын ИТХ-ын 2022 оны 6 сарын 17-ны өдрийн 05 тоот тогтоолоор 138540.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрийн 135 арга хэмжээг санхүүжүүлэхээр 512899.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 454375.7 мянган төгрөг буюу 88.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин, шимтгэлийн зардлаас 2838.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2565.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 1075.2 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлаас 580.0 мянган төгрөг, томилолтын зардлаас 599.0 мянган төгрөг, БГАҮТХ-ийн зардал 18925.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 18626.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн

зардлаас 5195.8 мянган төгрөг, хөрөнгийн санхүүжилтийн зардлаас 8122.0 мянган төгрөгийг хэмнэж 58523.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	7010-ОН-ийн өөрөө удирдах ёсны байгууллага	512899.6	454375.7	58523.9	87,84
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	334234,6	293610,5	40624,1	92.96
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	1200.0	800.0	400.0	66.67
1.3	80815-сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор	23736,0	18940,1	4795,9	79,79
1.4	80112- Нийтлэг үйлчилгээ	20581,2	19125,1	1456,1	92,92
1.5	80918- Бусад	95100,0	86978,0	8122,0	91,45
1.6	81102- Нөөц хөрөнгө	33547,8	30422,0	3125,8	90,68
		4500,0	4500,0	-	100,0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын шатахууны зардалд 1,355,4 мянга, Аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу бүх сумдад олгосон хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 300.0 мянга, аймгийн засаг даргаас 0-24 насны хүүхэд залуучуудын сургуульд хамрагдалтын судалгааны зардалд 250.0 мянга нийт 2,392.6 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу 2392.6 мянган төгрөгийг зарцуулсан байна

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын Ахлах аудитор П.Цэцэгдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар хэрэгжүүлсэн.

Цэцэрлэг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03/21 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 512889.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5128.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3846.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

Тайлант жилд тус байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны цалин, шимтгэлийн зардлаас 2838.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2565.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 1075.2 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлаас 580.0 мянган төгрөг, томилолтын зардлаас 599.0 мянган төгрөг, БГАҮТХ-ийн зардал 18925.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 18626.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардлаас 5195.8 мянган төгрөг, хөрөнгийн санхүүжилтийн зардлаас 8122.0 мянган төгрөгийг хэмнэж 58523.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цэцэрлэг сумын ЗДТГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 140 мэдээллийг хугацаанд нь 19 мэдээлэл хоцроон байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна.

#### 4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	0	0	0	0	100
Зөвлөмж	1	0	1	0	
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100</b>

2021 оны санхүүгийн тайлангаар 1 зөвлөмж авсан ба биелэлтийг 2022 оны 6 сарын 06-ны өдрийн 01/123 тоот албан тоотгоор хүргүүлсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй, харин залруулагдаагүй нийт 4485.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 4485.0 мянган төгрөгт 2 албан шаардлага хүргүүлээ.

### 5.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлант онд “Шилэн дансны тухай” хуулийн дагуу мэдээлэл байршуулахаас 19 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчил илэрлээ.  
Энэ нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “Мэдээлэл үэн зөв иж бүрэн байх, 4.1.3 “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4 “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, байршуулж ил тод болгоно гэснийг зөрчсөн байна.
2. Цэцэрлэг сумын Засаг даргын 2022.07.18-ны өдрийн А/70 тоот захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Эрдэнэ заяа бандида Лувсанпэрэнлэй гэгээнтэн мэндэлсний 380 жилийн ойг Мухар хужиртын рашаан дээр тэмдэглэн өнгөрүүлэх баяр наадмын шагналын зардалд 3085.0 мянган төгрөг, мөн 2022.09.23-ны өдрийн А/83 тоот захирамжаар “Цэцэрлэгт үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааны шагналын зардалд 1400.0 мянган төгрөг нийт 4485.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.  
Энэ нь “Хэмнэлтийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3. “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”; 15.1.5. “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.